

ЗОРЧИГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЭД ЗҮЙЛИЙГ ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, гаалийн болон бусад татваргүй нэвтрүүлэх барааны тоо хэмжээг тогтоох, зорчигчийн бусад бараанд гаалийн хяналт тавих, бүрдүүлэлтэд хийхэд энэ журмын зорилго оршино.

1.2.Зорчигчийн аяллын зорилго, хугацаа, жилд хэдэн удаа улсын хил нэвтэрсэн зэргээс шалтгаалан хувийн хэрэглээний эд зүйл болон зорчигчийн бусад барааны үнийн дүн, тоо хэмжээг тогтооно.

1.3.Зорчигчийн гар тээш болон аялж буй тухайн тээврийн хэрэгслийн ачаа тээшин дэх барааг дагалдах ачаанд, зорчигч аялалын хугацаанд өөр тээврийн хэрэгсэл болон чингэлэг, шуудан илгээмжээр илгээсэн барааг биеэс тусдаа илгээсэн ачаанд хамааруулна.

1.4.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгсэл гэдэгт зорчигчийн байнга оршин суугаа газарт улсын бүртгэлтэй хувийн тээврийн хэрэгслийг ойлгоно.

1.5.Зорчигчийн байнга оршин суугаа газар гэдэгт тухайн улсын иргэний, тухайн улсын харьяат иргэнтэй гэр бүл болсон, цагаачлах, хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, суралцах, мэргэжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болон хувийн бусад зорилгоор 180 хоногоос дээш хугацаагаар амьдарч байгаа гадаадын иргэний оршин суугаа улсыг ойлгоно.

1.6.Зорчигч, түүний хувийн хэрэглээний эд зүйл, бараа нь зорчигч улсын хилээр нэвтэрсэн үеэс гаалийн хяналтын бүсээс гарах хүртэл, гаалийн хяналтын бүсэд орсон үеэс гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргах хүртэл хугацаанд гаалийн хяналтад байна.

1.7.Зорчигчийн биедээ авч яваа хувийн хэрэглээний эд зүйл болон биеэс тусдаа илгээсэн ачаанд гаалийн бүрдүүлэлт хийх үндэслэл нь зорчигчийн гаалийн мэдүүлэг болно.

1.8.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд хамаарахгүй бөгөөд худалдааны шинжтэй буюу татвар ногдуулах барааг гаалийн байгууллагын CEPS болон Gaali.mn систем ашиглан “Хувь хүний барааны гаалийн мэдүүлэг”-ээр мэдүүлнэ.

1.9.Гаалийн байгууллага нь зорчигчийн бараанд тавих хяналт, шалгалтыг оновчтой зохион байгуулах зорилгоор зорчигчийн урьдчилсан мэдээлэл (API) болон зорчигчийн нэрийн бүртгэлийн мэдээлэл (PNR)-ийг ашиглана.

Хоёр. Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг
гаалийн хилээр нэвтрүүлэх

2.1.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд аяллын хугацаанд хэрэглэх, эсвэл байнга хэрэглэгддэг, шинж чанар, тоо хэмжээгээрээ худалдааны зориулалтгүй эд зүйлсийг ойлгоно. Үүнд:

2.1.1.Хувийн гоёл чимэглэл

2.1.2.Гар утас, ухаалаг төхөөрөмж, зөөврийн компьютер, дагалдах хэрэгсэл

2.1.3.Гэрэл зургийн аппарат, камер, дүрс бичлэгийн хэрэгсэл түүний дагалдах эд анги, дуран

2.1.4.Зөөврийн хөгжмийн зэмсэг, видео болон аудио тоглуулагч, радио, телевизор

2.1.5.Хүүхдийн тэрэг, хүүхдийн суудал (зорчиж буй хүүхдийн тоогоор)

2.1.6.Тахир дутуу иргэний тэргэнцэр

2.1.7.Спортын хэрэгсэл

2.1.8.Аяллын хугацаанд шаардагдах оношлогоо, эмчилгээний зориулалттай зөөврийн эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн дагалдах эд зүйл

2.1.9.Мэргэжлийн багаж хэрэгсэл (аяллын зорилго, нөхцөлд нийцүүлэн түр хугацаагаар ашиглах)

2.1.10.Гэр ахуйн бага оврын цахилгаан бараа

2.2.Зорчигч нь энэ журмын 2.1-д заасан бараанаас гадна дараах тоо хэмжээ бүхий эд зүйлийг гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлнэ.

2.2.1. Архины зүйлс 2 литр, дарс 2 литр, шар айраг 3 литр, янжуур 200 ширхэг, сигар, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүй, электрон тамхины төхөөрөмж 1 ширхэг, тухайн төхөөрөмжид зориулагдсан тамхины бэлдэц – 200ш, эсхүл 90мл хүртэл никотинтэй шингэн

2.2.2. Гадаадад 6 сараас дээш хугацаагаар сурч, ажиллаж байсан болон Монгол Улсад 6 сараас дээш хугацаагаар сурч, ажиллах иргэдийн хувийн эд хогшил, гэр ахуйн тавилга бусад хэрэгсэл шинэ хуучнаас үл хамааран тус бүр нэгээс дээшгүй.

2.2.3. Нотариатын, эсхүл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн баталгаажуулсан гэрчилгээнд заасан нэр төрөл, тоо хэмжээ бүхий өв залгамжлалын эд хөрөнгө /өв залгамжлалын эд юмс, үнэт эдлэлийг борлуулсан орлогоор худалдан авсан зүйлийг өв залгамжлалын эд хөрөнгөд тооцохгүй.

2.2.4. Гэрийн тэжээвэр амьтан нэр төрөл тус бүрээс 1-ээс илүүгүй,

2.3. Энэ журмын 2.2.1-д заасан бараа нь 21 насанд хүрээгүй, хилээр гараад 24 цагийн дотор буцаж орж байгаа зорчигчид хамаарахгүй.

2.4. Дараах бараа зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд хамаарахгүй бөгөөд “Хувь хүний барааны гаалийн мэдүүлэг”- ээр гаалийн бүрдүүлэлт хийхгүй.

2.4.1. Хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа

2.4.2. Худалдааны шинж чанартай буюу худалдааны хэмжээтэй бараа, түүний дотор барааны дээж, их хэмжээгээр авч яваа хүнс

2.4.3. Барилгын материал, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, автомашины сэлбэг

2.4.4. Түүх, соёлын дурсгалт зүйлс, палеонтологийн олдвор;

2.4.5. Үйлдвэрлэлийн зориулалттай түүхий эд, хагас боловсруулсан болон бараа материал

2.4.6. Үнэт металл, эрдэнийн чулуу, байгалийн болон гоёлын чулуу;

2.4.7. Мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд

Гурав. Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг
улсын хилээр нэвтрүүлэх

3.1. Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн тухай хуулийн 227 дугаар зүйлийг мөрдөнө.

Дөрөв. Зорчигчийн хувийн тээврийн хэрэгслийг
гаалийн хилээр нэвтрүүлэх

4.1. Зорчигчийн хувийн тээврийн хэрэгслийг тухайн зорчигчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон хилийн чанадад байх зөвшөөрөгдсөн хугацаанд хилээр 6 сар хүртэлх хугацаагаар нэвтрүүлж, бүртгэлээр хяналт тавих бөгөөд Монгол улсад орох гадаад улсын бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэл нь хариуцлагын даатгалд хамрагдсан байна.

4.2.Тээврийн хэрэгсэл нь зорчигчийн нэр дээр бүртгэлтэй байх бөгөөд өмчлөгчөөс бусад этгээд ашиглаж байгаа тохиолдолд өмчлөгчийн нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.

4.3.Гадаад улсад байнга оршин суух эрхтэйгээс бусад Монгол улсын иргэн гадаад улсын бүртгэлийн дугаартай автотээврийн хэрэгсэлтэй улсын хилээр орох тохиолдолд хилийн гаалийн байгууллага автотээврийн хэрэгслийн програмд бүртгэл хийж, гаалийн бүрдүүлэлтийн зохих горимд байршуулна.

4.4.Тээврийн хэрэгслийн жолооч нь CEPS болон Gaali.mn системийг ашиглан тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмын “Зорилго” хэсгээс “Түр - Аялал жуучлал” төрлийг сонгон, тээврийн хэрэгслийн мэдээллийг бөглөж гаалийн хилээр нэвтрэх хүсэлтийг гаалийн байгууллагад илгээнэ.

4.5.Хяналт, шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг тээврийн хэрэгсэлтэй тулган шалгаж, хяналт шалгалтын үр дүнг CAIS системд баталгаажуулан хилээр нэвтрүүлнэ.

4.6.Улсын хилээр орох гадаад улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн эзэмшигчид энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн автотээврийн хэрэгслийн гаалийн мэдүүлэг”-ийг хэвлэн “гаалийн хяналтад байгаа” тэмдэглэл хийж, баталгаажуулан өгнө.

4.7.Хилийн гаалийн байгууллага түр хугацаагаар нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийг улсын хилээр буцаан нэвтрүүлэх, эсхүл гаалийн бүрдүүлэлтийн зохих горимд байршуулах хүртэл хяналт тавина.

4.8.Түр хугацаагаар гаалийн хилээр нэвтрүүлсэн автотээврийн хэрэгслийг буцаан нэвтрүүлэхдээ тээврийн хэрэгсэл эзэмшигч нь анхны “бүртгэлийн дугаар”-ыг татаж, улсын хилээр буцаан нэвтрүүлэх хүсэлт илгээнэ.

4.9.Хилийн гаалийн байгууллага энэ журмын 4.8-д заасан хүсэлтийг үндэслэн тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсэд оруулахад гаалийн улсын байцаагч цахим системээс автоматаар хуваарилагдах бөгөөд хяналт, шалгалт хийж үр дүнг системд оруулан баталгаажуулснаар системд хаалт хийгдэнэ.

4.10.Гадаад улсад бүртгэлтэй тээврийн хэрэгсэл буцан гарч байгаа тохиолдолд энэ журмын 4.9-д заасан “Монгол Улсын хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн автотээврийн хэрэгслийн гаалийн мэдүүлэг”-ийг хураан авч, архивт 1 жил хүртэлх хугацаагаар хадгална.

4.11.Түр хугацаагаар оруулсан авто тээврийн хэрэгслийг эзэмшигч гадаадын иргэн бусдад шилжүүлэх, худалдах, гаалийн баталгаат агуулахад хадгалах тохиолдолд гаалийн бүрдүүлэлтийн зохих горимд байршуулна. Гаалийн мэдүүлгийн ачааны манифест хэсэгт тээврийн хэрэгслийн “Бүртгэлийн дугаар”-ыг

татаж, мэдүүлэг хүчин төгөлдөр болсноор тээврийн хэрэгслийн гаалийн хилээр орсон бүртгэл хаагдана.

4.12.Бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага автотээврийн хэрэгслийн бүрдүүлэлт хийсэн мэдүүлгийн дугаарыг бичин “Монголын гааль зөвшөөрөв” тэмдэг даран, баталгаажуулалт хийж тээврийн хэрэгслийн эзэмшигчид буцаан олгох бөгөөд улсын хилээр буцаж гарахдаа уг мэдүүлгийг “Зорчигчийн гаалийн мэдүүлэг”-ийн хамт хилийн гаалийн байгууллагад гаргаж өгнө.

4.13.Түр хугацаагаар нэвтрүүлсэн автотээврийн хэрэгслийг анх хяналтад хамруулсан гаалийн байгууллага энэ журмын 4.1-д буцаан нэвтрүүлээгүй тохиолдолд эзэмшигчийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагад мэдэгдэж, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, тээврийн хэрэгслийг нэн даруй буцаан гаргуулах эсхүл гаалийн бүрдүүлэлтийн зохин горимд байршуулна.

Тав. Зорчигчийн галт зэвсэг, бэлэн мөнгөнд тавих гаалийн хяналт

5.1.Зорчигч арван таван сая төгрөгөөс дээш, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний валютыг биедээ авч яваа, тохиолдолд зорчигчийн гаалийн мэдүүлгийг 2 хувь бичин хил нэвтрэх гаалийн байгууллагын хяналт тавьж буй гаалийн улсын байцаагчид өгч, гаалийн байгууллагад мэдүүлнэ.

5.2.Мэдүүлэг хүлээн авсан гаалийн улсын байцаагч мэдүүлгийг бэлэн мөнгөтэй тулган шалгаж, “Зорчигчийн гаалийн мэдүүлэг” -ийг хувийн тэмдэг, гарын үсгээр баталгаажуулан нэг хувийг зорчигчид өгч, нөгөө хувийг авч үлдэн тухайн ажлын өдөрт багтаан CAIS системийн “Бэлэн мөнгөний хяналт” хэсэгт Гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжээс өгсөн зааврын дагуу бүртгэнэ.

5.3.Улсын хилээр түр хугацаагаар нэвтрүүлж буй зорчигчийн галт зэвсэг /ангийн, спорт сургалтын/-ийг гаалийн хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч шалгаж, зөвшөөрлийн бичгийн зохих хүснэгтэд тэмдэглэгээ хийж баталгаажуулан, гаалийн улсын байцаагч CAIS системийн Галт зэвсгийн бүртгэл хэсэгт бүртгэнэ.

5.4.Улсын хилээр буцаан нэвтрүүлж байгаа галт зэвсгийг гаалийн улсын байцаагч анх нэвтрүүлэхэд үүсгэсэн бүртгэлийн мэдээлэлтэй тулган шалгаж, Галт зэвсгийн бүртгэл хэсэгт баталгаажуулан хаалт хийнэ.

5.5.Төрийн тусгай хамгаалалтын болон олон улсын хамтарсан сургуулилтын зориулалтаар гаалийн хилээр нэвтрүүлэх галт зэвсэгт эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу хяналт тавина.

Зургаа. Зорчигчийн бараанд тавих гаалийн хяналт, бүрдүүлэлт

6.1.Олон улсын нисэх онгоцны буудал болон хос гарцын систем нэвтрүүлсэн хилийн боомтоор нэвтрэх зорчигч биедээ авч яваа болон биеэс тусдаа илгээсэн барааны шинж, ангилал, үнийн дүн, мэдүүлэх шаардлагад үндэслэн гаалийн хяналтын “улаан” эсхүл “ногоон” гарцыг сонгож нэвтрэнэ.

6.2.Гаалийн улсын байцаагч зорчигчийн гаалийн мэдүүлгийг хүлээн авсан, эсхүл зорчигч ногоон гарцыг сонгож нэвтэрсэн үеэс гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.

6.3.Дараах бараатай зорчигч гаалийн байгууллагад зорчигчийн гаалийн мэдүүлгээр мэдүүлнэ.

6.3.1.15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх;

6.3.2.гаалийн болон бусад татвар төлөх бараа;

6.3.3.энэ журмын 2.4-т заасан зорчигчийн хувийн хэрэглээнд хамаарахгүй бараа

6.3.4.энэ журмын 2.2.2-2.2.4-т заасан хувийн хэрэглээний эд зүйл;

6.3.5.энэ журмын 2.3.1-д заасан тоо хэмжээнээс илүү бараа;

6.3.6.биеэс тусдаа илгээсэн ачаа, бусдад дамжуулах бараа

6.3.7.мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис;

6.3.8.галт зэвсэг

6.4.Зорчигч ногоон гарцыг сонгон гаалийн хилээр нэвтэрсэн тохиолдолд хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан, гаалийн болон бусад татвар төлөх, биеэс тусдаа явуулсан, бусдад дамжуулах бараагүй, валют, үнэт металл зэрэг гаальд мэдүүлэхээр заасан бараа байхгүй хэмээн мэдүүлсэнд тооцно.

6.5.Энэ журмын 6.3-т заасан бараатай зорчигч болон гаалийн байгууллагын шаардсанаар мэдүүлэг гаргах зорчигч “Зорчигчийн гаалийн мэдүүлэг”-ийг нөхөн бичиж, “улаан гарц”-аар нэвтрэнэ.

6.6.Гаалийн байгууллага дараах тохиолдолд зорчигчийн бараанд гаальд мэдүүлэхээс өмнө урьдчилсан шалгалт хийж болно:

6.6.1.Олон улсын болон үндэсний аюулгүй байдлын шаардлагаар;

6.6.2.Эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж тогтоогдсон зорчигчид;

6.6.3.Хил дамнасан хориглосон болон хязгаарласан барааг илрүүлэх зорилгоор;

6.6.4.Хорио цээрийн болон эрүүл ахуйн хяналт.

6.7.Урьдчилсан шалгалтыг рентген болон бусад зориулалтын төхөөрөмж, эрэлч нохой, мэргэжлийн шинжээчийн үзлэг хийх, зорчигчийг нарийвчлан шалгах зэрэг хэлбэрээр хийнэ.

6.8.Урьдчилсан шалгалт хийснээр зорчигчийг гаалийн мэдүүлэг гаргах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд гаальд мэдүүлэх үүрэг хэвээр байна.

6.9. Гаалийн байгууллага эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан “Зорчигчийн гаалийн мэдүүлэг” нөхөн бичээгүй зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс, бараанд гаалийн шалгалт хийж болно.

6.10.Гаалийн байгууллага зорчигчийн урьдчилсан мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтын төхөөрөмжөөр хийгдсэн шалгалтын үр дүн болон бусад эх сурвалжид үндэслэн зорчигчийн бараанд хяналт, шалгалт хийнэ.

6.11.Зорчигч ногоон гарцыг сонгосон боловч энэ журмын 6.3-д заасан бараа авч яваа гэх сэжиг илэрсэн, эрсдэлийн үнэлгээгээр хяналт шаардлагатай гэж үзсэн, мэдээлэл, гомдол, мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд гаалийн байгууллага шалгалт хийнэ.

6.12. Гаалийн байгууллага зорчигчийн бараанд гаалийн хяналт тавихдаа Гаалийн тухай хуулийн 240 дүгээр зүйлд заасан хяналтын хэлбэрүүдээс эрсдэлийн үнэлгээнд суурилсан, зорчигчийн урсгалд саад учруулахгүй аргыг сонгон хэрэглэнэ.

6.13.Зорчигч гаалийн мэдүүлгийг нөхөн бичиж, гарын үсэг зурж гаалийн улсын байцаагчид өгнө. Биеэс тусдаа явуулсан ачаанд гаалийн мэдүүлгийг 2 хувь бичих бөгөөд нэгдүгээр хувийг хилийн гаалийн байгууллага авч, хоёрдугаар хувийг биеэс тусдаа илгээсэн бараанд гаалийн эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагад хүргүүлэхээр эзэнд нь өгнө.

6.14. Шалгалтаар гаалийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй илрээгүй бол гаалийн улсын байцаагч мэдүүлэгт гарын үсэг зурж, хувийн дугаар тэмдгээр баталгаажуулна. Хэрэв зөрчил илэрсэн бол “Зөрчил шалган шийдвэрлэсэн баримт”-д хавсаргаж, холбогдох арга хэмжээг авна.

6.15.Насанд хүрээгүй зорчигчийн барааг эцэг, эхийн эсхүл асран хамгаалагчийн гаалийн мэдүүлэгт бичнэ.

6.16.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд хамаарахгүй бөгөөд 3000000 /гурван сая/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий худалдааны шинжтэй бараанд “Хувь хүний барааны гаалийн мэдүүлэг”-ээр, 3.000.001 төгрөг /гурван сая/-өөс дээш бол гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлт хийнэ.

6.17.Гаалийн байгууллага зорчигчийн мэдүүлсэн гаалийн мэдүүлгийг цахимаар хүлээн авч, шаардлагатай бол холбогдох бичиг баримтыг гаргуулан авч гаалийн бүрдүүлэлт хийнэ. Эдгээр бичиг баримт байхгүй тохиолдолд мэдүүлэгчээр тайлбар бичүүлж авна.

6.18. Гаалийн хилээр оруулах, нэр төрөл тус бүрээс нэг ширхэгээс илүүгүй гэрийн тавилгад үнийн дүн харгалзахгүй “Хувь хүний барааны гаалийн мэдүүлэг”-ээр гаалийн бүрдүүлэлт хийнэ.

6.19.Дамжин өнгөрөх зорчигчийн гаалийн мэдүүлэгт тэмдэглэсэн бараа нь Монгол Улсад орсон үеэс гарах хүртэлх хугацаанд гаалийн хяналтад байна.

6.20.Гаалийн хилээр нэвтрэх этгээд барааг биедээ нуусан гэх үндэслэл бүхий сэжиг байгаа бол биед нь үзлэг хийнэ. Үзлэг хийхдээ Гаалийн тухай хуулийн 247 дугаар зүйлийг мөрдөнө.

6.21.Хэрэв зорчигч гаалийн байгууллагад мэдүүлэх үүргээ биелүүлээгүй, ногоон гарцаар мэдүүлэхгүйгээр нэвтэрч хууль зөрчсөн нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.22.Гаалийн байгууллага зорчигчийн хил нэвтрэх давтамж, барааны шинж чанарт үндэслэн “давтамжтай зорчигч”-ийн бүртгэл үүсгэн, эрсдэлийн үнэлгээ хийнэ.

6.23.Гаалийн байгууллага нь зорчигчийн бараанд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор зорчигч хилээр нэвтрэхтэй холбоотой мэдээллийг хил дээр үйл ажиллагаа явуулж буй хилийн хяналтын бусад байгууллагуудтай солилцоно.

6.24.Гаалийн байгууллага нь зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах, боловсруулах, эрсдэлийн үнэлгээ хийх зорилгоор “Зорчигчийн мэдээллийн төв”-тэй хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, холбогдох өгөгдлийг ашиглах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.25.Гаалийн байгууллага нь зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем, гаалийн цахим системийн уялдааг үе шаттайгаар сайжруулж, автомат эрсдэлийн үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлэн зорчигчийг улаан болон ногоон гарцаар нэвтрүүлэх урсгалыг автомат системээр удирдан чиглүүлнэ.

6.26.Энэ журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг Гаалийн тухай болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛСАН АВТОТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

1. Эзэмшигчийн мэдээлэл

Нэр:

Үндэсний харьяалал:

Паспорт / Иргэний үнэмлэх №:

Оршин суугаа улс / хот:

Холбоо барих (утас, e-mail):

2. Автотээврийн хэрэгслийн мэдээлэл

Улсын бүртгэлийн дугаар:

VIN / Арлын дугаар:

Үйлдвэрлэгч, загвар:

Үйлдвэрлэсэн он: Өнгө:

Хөдөлгүүрийн багтаамж (см³):

Суудлын тоо:

3. Нэвтрэх зорилго ба хугацаа

Зорилго (☒ Жуулчлал / ☐ Бизнес / ☐ Бусад):

Монгол Улсад орсон огноо:

Монгол Улсаас гарах төлөвлөсөн огноо:

Нийт хугацаа:

4. Даатгалын мэдээлэл

Даатгалын компани:

Даатгалын гэрээ болон бусад мэдээлэл

Хүчинтэй хугацаа: (☒ Замын хөдөлгөөний хариуцлагын даатгал хүчинтэй)

5. Гаалийн хяналтын тэмдэглэл

Орох бүртгэлийн дугаар:

Хяналт, шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч:

Нэр:

Гарын үсэг:

Огноо:

Хяналтын тэмдэг: ☐ Гаалийн хяналтад байгаа / Хувийн тэмдэг

Гарах үед бүртгэлийг хаасан огноо:

Хяналт, шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч:

Нэр:

Гарын үсэг:

Хяналтын тэмдэг: ☐ Монголын гааль зөвшөөрөв / Хувийн тэмдэг

6. Баталгаа

Дээр дурдсан мэдээлэл үнэн зөв бөгөөд энэхүү автотээврийн хэрэгслийг Монгол Улсад түр хугацаагаар нэвтрүүлж, худалдах, шилжүүлэх, хууль бус үйлдэл хийхгүй бөгөөд тогтоосон хугацаанд буцаан гаргана гэдгээ баталж байна.

Эзэмшигчийн гарын үсэг: _____

